

“ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА” ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 1. Ерөнхий мэдээлэл** “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” мэдээлэл цуглуулах, мэдээллийг зориулалтын программд шивж оруулах ажлуудыг захиалагчийн мэргэжил, арга зүйн удирдлага, хяналт дор гүйцэтгэх
- 2. Зөвлөхийг сонгох ажиллагаа** Зөвлөх үйлчилгээний зарлалыг 2020 оны 04 сарын 22-нд “Өдрийн сонин”-д нийтлүүлсэн ба 4 байгууллага тендерт оролцох санал ирүүлсэн. Үнэлгээний хорооны хурлын шийдвэрээр 4 байгууллагыг хураангуй жагсаалтад оруулан тендерийн урилга хүргүүлсэн.
- 3. Техникийн саналын үнэлгээ** “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад тендер ирүүлсэн “IRIM” ХХК, SICA ХХК-ний техникийн саналд үнэлгээний хорооны гишүүд үнэлгээ хийж нэгтгэв. ЗҮТББ-д заасан үнэлгээний дэд үзүүлэлт болон холбогдох онооны талаарх үндэслэл:
- (а) Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага
 - (б) Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал
 - (в) Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх ахлах судлаач, судлаачдын чадвар болон туршлага

ТББ-ийн ТӨХ-ийн 1.1-д зааснаар Чанарын үнэлгээний аргаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.3 зүйлд зааснаар техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж, тухайн зөвлөхтэй санхүүгийн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох хэлэлцээр хийх зарчмаар зохион байгуулж явууллаа..

Үнэлгээний хорооны үнэлгээгээр техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан “SICA” ХХК-тай санхүүгийн санал болон бусад нөхцлийг тохиролцсоны үндсэнд “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олголоо.